



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/78

Шивээговь сум

Хүүхдийн төлөө зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 17 дугаар зүйлийн 17.1.1, аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/29 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Хүүхэд хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүүхдийн эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохицуулах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүүхдийн төлөө зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	(Засаг дарга)
Нарийн бичгийн дарга:	(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Гишүүд:	(1 дүгээр багийн Засаг дарга)
	(2 дугаар багийн Засаг дарга)
	(Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан)
	(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сум хариуцсан мэргэжилтэн)
	(Цагдаагийн хэсгийн дарга)
	(Шивээ Овоо хувьцаат компанийн Хүний нөөцийн албаны дарга)
	(Төрийн бус байгууллагын төлөөлөл)

2. Хүүхдийн эрхийг хангах, Хүүхдийг хөгжүүлэх, сурч боловсрох аюулгүй орчноор хангах, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг /Зөвлөл/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/58 дугаар "Хүүхдийн зөвлөл байгуулах тухай" захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ



42121-445